☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн
нэр, огноо:

МУ-ын Шадар сайдын 2025 оны 04-р сарын
02-ны өдрийн 54-р тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025.06.02

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

2025.05.28

Байгууллагын нэр:

Хүнсний аюулгүй байдлын үндэсний
лавлагаа лаборатори

Нэгжийн нэр:

Захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс

Албан тушаалын нэр:

Архивч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТУМ-3

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Чингисийн өргөн чөлөө-75, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот-17042, Монгол Улс

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын архивын сан хөмрөгийг Архивын тухай хууль тогтоомжийн хүрээнд
бүрдүүлэх, бүргэл хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Захиргаа, хамтын
ажиллагааны хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Архивын тухай хууль тогтоомжийн дагуу архивын баримтын сан хөмрөгт хүлээн авах, тоо
бүртгэл хөтлөх.

2.Архивын баримтыг хадгалж хамгаалах, сан хөмрөгөөс ашиглалтанд олгох,архивын баяжуулалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцан гүйцэтгэх, хяналт тавих;			
3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Гүйцэтгэх- Г, Хянах- Х, Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Бүтцийн нэгж, албан хаагчдаас архивын баримтыг жил бүрийн Нэгдүгээр улиралд бүртгэлээр хүлээн авах, баримтыг зөв ангилсан эсэхэд хяналт тавих, заавар, зөвлөгөө өгөх,	Хэрэгжүүлсэн ажлын тоо, үр дүн	Г, Х
	2.Хадгаламжийн нэгжийг нягтлан шалгах, хадгалалтын хугацаагаар ангилан төрөлжүүлж, тавиурт байрлуулах,	Хэрэгжүүлсэн ажлын тоо, үр дүн	Г, Х
	3.Сан хөмрөгт тоо бүртгэлийн холбогдох баримтууд, сан хөмрөгийн гэрчилгээ хөтлөх, чийг дулааны хэмжээнд хяналт тавих,	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	4.Сан хөмрөгт шүүгээ, тавиур, тавцан дах баримтын байрлалын заалт хийх, 7 хоногт 3 удаа цэвэрлгээ, үйлчилгээ хийж байх,	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	5.Байгууллагын архивын үйл ажиллагааг улирал, хагас жил, жилээр төлөвлөж архивын тоо бүртгэлийн баримт бичгийг хөтлөх, баяжилт хийхэд архив, бичиг хэргийн эрхлэгчид дэмжлэг үзүүлэх,	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г,Х
	6.Байгууллагын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхэд бэлтгэх, сонгох, төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэхэд архив, бичиг хэргийн эрхлэгчид дэмжлэг үзүүлэх.	Хэрэгжүүлсэн ажлын тоо, үр дүн	Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын удирдлага, нэгжүүдийг архивын мэдээллээр хангах,	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	2.Архиваас үзүүлж буй үйлчилгээг шуурхай болгох арга хэмжээ авах,	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	3.Архивт хүлээн авсан баримтыг архивын шаардлагын дагуу цэгцлэх, хадгаламжийн нэгжийн данс, бүртгэл хөтлөх,	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	4.Албан хаагч, иргэн, байгууллагад холбогдох журмын дагуу архивын баримт ашиглуулах, түр олгосон талаарх бүртгэл хөтлөх, бүрэн бүтэн байдлыг шалган хүлээж авах,	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г,Х

	5.Байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу павлагаа олгох.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	6.Архивын баримтын тооллого хийх, архивын талаарх авах арга хэмжээний санал боловсруулж архив, бичиг хэргийн эрхлэгчээр дамжуулан удирдлагад танилцуулах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
3-р зорилтын хүрээнд	1.Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, танилцуулах, тайлагнах,	Төлөвлөгөө боловсруулж танилцуулж тайлагнасан байна.	Г, Х
	2.Хариуцсан чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох саналаа танилцуулах.	Нотолгоонд тулгуурласан саналын тоо	Г,Х
	3.Хариуцсан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаатай холбоотой тайлан, судалгаа, танилцуулга, мэдээллийг боловсруулж, удирдлага, хамт олныг мэдээлнээр хангах.	Ажлын тоо, үр дүн	Г, Х
	4.Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах.	Хуул тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байдал	Г, Х
	5.Хууль тогтоомжоор заасан бусад чиг үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг шуурхай үр дүнтэй хэрэгжүүлэх.	Үүрэг даалгаварын тоо, хэрэгжсэн үр дүн	Г, Х
	6.Үйл ажиллагааны явцад үүсч хөтөгдсөн баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн, стандарт шаардлагын дагуу бэлтгэж, архивлах.	Архивласан хадгаламжийн нэгжийн тоо, устгах акт үйлдсэн байдал.	Г, Х
	7.Удирдлагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу ажлын хэсэг, комисст ажиллах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх		
Мэргэжил	- Эрх зүй /0421/, - Номын сан, мэдээлэл, архив судлал/0322/, - Лабораторийн чиг үүрэгт хамаарах /хими, биологи, физик г.м/ бусад		
Мэргэшл	Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээлэл технологийн чиглэлээр мэргэшлийн сургалтад хамрагдсан бол давуу тал болно.		
Туршлага	Төрийн албанд ажилласан туршлагатай бол давуу тал болно.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- байгууллагын бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөгөө өгөх;	

	- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвартай байх; - ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашигладаг байх; - жондорийн тэгш байдлыг хангах; - бусад.
--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалтны шууд харъяалан удирдах албан тушаалын нэр:

Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харъяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Бүтцийн нэгж;
- Стандарт, хэмжил зүйн газар
- Иргэн, аж ахуйн нэгж,
- Бусад

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА ТЕХНИКИЙН
МЕНЕЖЕР Б.АРВИНТУЛГА

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Байгууллагын нэр:

МУ-ын Шадар сайдын тушаал

Шийдвэрийн огноо: 2025.04.02

Дугаар: 54

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИ

Шийдвэрийн огноо: 2025/05/28

Дугаар: А/38

(тамга/тэмдэг)

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ О.НАНДИН-ЭРДЭНЭ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Монгол Улсын Шадар сайдын
2025 оны 04 дүгээр сарын 02-ны
өдрийн 54 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (цаашид "ХАБҮЛЛ" гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-ийн зорилго нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Хүнсний аюулгүй байдлыг хангахад лавлагаа лабораторийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги болон бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Энэхүү хөтөлбөрийг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.1 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль болон Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоол, "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжуудыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль, эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль;
- Ургамал хамгааллын тухай хууль;
- Таримал ургамлын үр, сортын тухай хууль;
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль;
- Цөмийн энергийн тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Байгууллагын нууцын тухай;
- Шилэн дансны тухай хууль;

- Архивын тухай хууль;
- Төрийн нууцын тухай;
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, олон улсын байгууллагуудын зөвлөмж, улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, үндэсний хөтөлбөр бусад улс орны лавлагаа лабораториудын туршлага, нийтлэг жишгийг ашиглав.

1.5. Үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

ХАБҮЛЛ нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд дотоодын болон импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх чанар, аюулгүйн үзүүлэлтийг батлагдсан арга аргачлалаар, орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан тодорхойлж, лавлагаа лабораторийн үйл ажиллагааг олон улсын жишилт хүргэх, итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх стандартын сургалт зохион байгуулах, үр чадварын сорилтыг зохион байгуулах, шинжилгээний үр дүнгийн мэдээллийн санг бүрдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд хууль тогтоомжийн хүрээнд өргөн хүрээтэй, уян хатан хандаж, зөв зохистой удирдаж зохицуулна.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

ХАБҮЛЛ-ийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь аж ахуйн нэгж хэрэглэгчийн эрэлт, захиалга, даалгавар байхаар тодорхойлов. Эдгээр хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



ХАБҮЛЛ-ийн үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Монгол Улсын Шадар сайд, Шадар сайдын ажлын алба, Стандарт хэмжил зүйн газар байна.

ХАБҮЛЛ-ийн стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч болон бусад хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцаат зохицуулахад чиглэнэ.

ХАБҮЛЛ-ийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоон зохион байгуулалтын бүтцийн нэгжийг тодорхойлж, зорилт, чиг үүргийг төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод бүрэн тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

ХАБҮЛЛ-ийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүнсний аюулгүй байдлыг хангахтай уялдуулан үндэсний лавлагаа лабораторийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн өндөр түвшинд баталгаа, нотолгоо гаргаж, зөвлөмжөөр хангахад оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

ХАБҮЛЛ нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана.

2.2.1. Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, хүнсний шинжилгээний үр дүнгийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

2.2.2. Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ур чадварын сарилтыг зохион

байгуулах, мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх стандартын сургалт зохион байгуулах;

2.2.3.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх биологи, хими, физик, цацрагийн бохирдлыг тодорхойлох, үр тариа, таримал ургамалд хортон шавьж тодорхойлох сорилт шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаа хийх, эрсдэлийг бууруулах санал боловсруулах, зөвлөмж гаргана.

2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго

ХАБҮЛЛ-ийн эрхэм зорилго нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогод нийцүүлэн үндэсний сорилтын лабораториудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх хими, биологи, цацрагийн бохирдлын сорилт шинжилгээ, тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж, чанартай төрийн үйлчилгээг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөд тулгуурлан хэрэглэгчдэд хүргэхэд оршино.

2.4.Үйл ажиллагааны зарчим

ХАБҮЛЛ нь үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд тулгуурласан, хараат бус хөндлөнгийн байр сууринаас хийсэн үнэн бодит хэмжилт шинжилгээний дүнгээр хэрэглэгчийг хангах зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллана.

2.5.Үйл ажиллагааны стратегийн зорилт

ХАБҮЛЛ нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1.Төрийн албаны манлайллыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, санхүү эдийн засгийн төлөвлөлтийн үр өгөөжийг дээшлүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;

2.5.2.Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хүнсний шинжилгээний үр дүнгийн мэдээллийн нэгдсэн санг өргөтгөж, хөгжүүлэх;

2.5.3.Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандарт арга зүйг нэвтрүүлж, багийн чадавхыг нэмэгдүүлэх;

2.5.4.Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үр чадварын сорилтыг зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх стандартын сургалт зохион байгуулж, шинжилгээний аргын нэгдмэл байдлыг хангах;

2.5.5.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх биологийн бохирдол (бактери, вирус, мөөгөнцөр, паразит, хувиргасан амьд организм г.м)-ыг тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

2.5.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх химийн бохирдол (пестицид, эмийн үлдэгдэл, хүнсний нэмэлт, микотоксин, хүнд метал, харшил үүсгэгчид г.м)-ыг тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийг олон улсын жишигт нийцүүлэн

2.6.2.5.Мэдээллийн сангийн өгөгдөлд хийсэн дүн шинжилгээ, холбогдох тайлан, мэдээллээр удирдлагыг хангах;

2.6.3.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим алдагдаж, хүн амын дунд хүнсээр дамжих халдвар, хордлого гарах эрсдэлт байдал үүссэн үед аюулыг үнэлэх, хүний эрүүл мэнд, мал, амьтан, байгаль орчин, эдийн засагт учирч болзошгүй эрсдэлийн нөлөөллийг тодорхойлж, эрсдэлийн түвшинг тогтоох;

2.6.3.2.Хүнсний аюулгүй байдлын төлөв байдлыг тогтоох тандалт судалгааг төлөвлөж хэрэгжүүлэх;

2.6.3.3.Эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандарт арга зүйг нэвтрүүлж, батийн чадавхыг нэмэгдүүлэх;

2.6.4.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.4.1.Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

2.6.4.2.Ур чадварын сорилтыг зохион байгуулж, шинжилгээний артын нэгдмэл байдлыг хангах;

2.6.4.3.Мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх стандартын сургалт зохион байгуулах;

2.6.5.Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.6.5.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх биологийн бохирдол (бактери, вирус, мөөгөнцөр, паразит, хувиргасан амьд организм г.м)-ыг бүрэн тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.6.5.2.Лабораторийн ажилтны ур чадварыг сайжруулах, ахисан түвшинд сургах;

2.6.5.3.Лабораторийн зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн итгэмжлүүлэх;

2.6.5.4.Хараат бус хөндлөнгийн бодит сорилт шинжилгээний дүнгээр хэрэглэгчдийг хангах;

2.6.5.5.Үндэсний болон бус нутаг, бусад орны холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлж, шинжилгээний шинэ арга зүй боловсруулах, нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, харилцан мэдээлэл, туршлага солилцох;

2.6.5.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээний маргаан таслах баталгаажуулах шинжилгээг хийх;

2.6.5.7.Хүнсний биологийн бохирдлын аюулгүйн үзүүлэлтийн норм, стандарт, техникийн баримт бичгийн төсөл боловсруулах санал өгөх;

2.6.6.Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.6.6.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх химийн бохирдол (пестицид, эмийн үлдэгдэл, хүнсний нэмэлт, микотоксин, хүнд метал, харшил үүсгэгчид г.м)-ыг бүрэн тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.6.6.2.Лабораторийн ажилтны ур чадварыг сайжруулах, ахисан түвшинд сургах;

2.6.6.3.Лабораторийн зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн итгэмжлүүлэх;

2.6.6.4.Хараат бус хөндлөнгийн бодит сорилт шинжилгээний дүнгээр хэрэглэгчдийг хангах;

2.6.6.5.Үндэсний болон бус нутаг, бусад орны холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлж, шинжилгээний шинэ арга зүй боловсруулах, нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, харилцан мэдээлэл, туршлага солилцох;

2.6.6.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээний маргаан таслах баталгаажуулах шинжилгээг хийх;

2.6.6.7.Хүнсний химийн бохирдлын аюулгүйн үзүүлэлтийн норм, стандарт, техникийн баримт бичгийн төсөл боловсруулах санал өгөх;

2.6.7.Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.6.7.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх физикийн бохирдол (цацраг идээхт бодис, хуванцар г.м)-ыг илрүүлэх сорилт шинжилгээний лабораторийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.6.7.2.Лабораторийн ажилтны ур чадварыг сайжруулах, ахисан түвшинд сургах;

2.6.7.3.Лабораторийн зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн итгэмжлүүлэх;

2.6.7.4.Хараат бус хөндлөнгийн бодит сорилт шинжилгээний дүнгээр хэрэглэгчдийг хангах;

2.6.7.5.Үндэсний болон бус нутаг, бусад орны холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлж, шинжилгээний шинэ арга зүй боловсруулах, нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, харилцан мэдээлэл, туршлага солилцох;

хөгжүүлэх;

2.5.7.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх физикийн бохирдол (цацраг идэвхт бодис, хуванцар г.м)-ыг илрүүлэх сорилт шинжилгээний лабораторийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

2.5.8.Ургамал, ургамлын гэрэлтэй хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хорио цээрийн сорилт шинжилгээний лабораторийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

2.6.Үйл ажиллагааны зорилт

ХАБҮЛЛ-ийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтуудыг дэвшүүлэн ажиллах бөгөөд зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ:

2.6.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1.ХАБҮЛЛ-ийн богино ба урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах;

2.6.1.2.Төрийн албаны манлайллыг хангах, хүний нөөцийг бүрдүүлэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх;

2.6.1.3.Олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.6.1.4.Салбарын эрх зүйн орчныг зохицуулах хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн сайжруулах;

2.6.1.5.Хууль тогтоомж, удирдах дээд байгууллагын удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

2.6.1.6.Үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн технологийг хөгжүүлэх;

2.6.1.7.Төсөв санхүүгийн удирдлагаар хангах замаар байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.6.2.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1.Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцооны цахим систем (цаашид "LIMS" гэх)-ийг өргөтгөж, сайжруулах;

2.6.2.2.LIMS-ийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дотоод, гадаад, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.6.2.3.LIMS-ийн сургалт хийх, мэргэжил арга зүйгээр хангах;

2.6.2.4.Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах баримт бичгийн бүрдүүлэлтийг сайжруулах;

2.6.7.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээний маргаан таслах баталгаажуулах шинжилгээг хийх;

2.6.7.7.Хүнсний физикийн бохирдлын аюулгүйн үзүүлэлтийн норм, стандарт, техникийн баримт бичгийн төсөл боловсруулах санал өгөх;

2.6.8.Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.6.8.1.Ургамал, ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хорио цээрийн сорилт шинжилгээний лабораторийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.6.8.2.Лабораторийн ажилтны ур чадварыг сайжруулах, ахисан түвшинд сургах;

2.6.8.3.Лабораторийн зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн итгэмжлүүлэх;

2.6.8.4.Хараат бус хөндлөнгийн бодит сорилт шинжилгээний дүнгээр хэрэглэгчдийг хангах;

2.6.8.5.Үндэсний болон бүс нутаг, бусад орны холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлж, шинжилгээний шинэ арга зүй боловсруулах, нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, харилцан мэдээлэл, туршлага солилцох;

2.6.8.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээний маргаан таслах баталгаажуулах шинжилгээг хийх;

2.6.8.7.Ургамал, ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хорио цээрийн шинжилгээний үзүүлэлт норм, стандарт, техникийн баримт бичгийн төсөл боловсруулах санал өгөх;

2.7.Үйл ажиллагааны стратегийн загвар

Үйл ажиллагааны стратегийн загварыг дараах байдлаар тодорхойлж байна.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

үндэслэн ХАБҮЛЛ-ийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны дараах загварыг санал болгож байна.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.4. Зохион байгуулалтын бүтэц

Үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус байгууллагын зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна.

3.4.1. Захиргаа, хамтын ажиллагааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд стратегийн төлөвлөлт хийх, нэгдсэн бодлогыг боловсруулах, хүний нөөцийн манлайллыг хангах, удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага, ажилтнуудад эрх зүйн зөвлөгөө болон дотоод дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, удирдлага болон ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, кийгмийн баталгааг хангах, салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг, төрийн албан хаагч бүхий мэргэшсэн хүний нөөцөөр газрын тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ. Энэ нь газрын даргаас шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

3.4.2.Эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 болон 3 дугаар зорилтын хүрээнд Хүнсний тухай болон хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилт, түүнтэй холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан чиг үүрэг, арга хэмжээтэй уялдуулан тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хүнсний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтыг боловсруулан батлуулах, лабораторийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, удирдлага болон албан хаагчдыг мэдээлэл, арга зүйгээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.4.3.Ур чадварын сорилт, сургалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн дагуу хүнсний лабораториудын ур чадварын сорилтын хөтөлбөр зохион байгуулах, хөтөлбөрийн дараах болон нэгдсэн сургалтыг зохион байгуулах, төрийн болон орон нутгийн сүлжээ, хувийн хэвшлийн лабораториудыг мэргэжил арга зүйгээр хангах, шинжилгээний үр дүнгийн нэгдмэл байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.4.4.Санхүү бүртгэлийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөөцийн бэлэн байдлыг хангах, шууд захирагчийн төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, салбарын санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах асуудлыг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.4.5.Инженер техникийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай инженер, техникийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, байр ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой асуудлыг хариуцан хэрэгжүүлнэ. Мөн өргөх байгууламжид техникийн

2.8.Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө

ХАБҮЛЛ-ийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны Стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж ажиллана. Стратеги төлөвлөгөө нь төсвийн төвлөрүүлэн захирагч (СХЗГ-ын дарга)-тай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний салшгүй хэсэг байна.

Гурав. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

3.1.1.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав.

3.1.2.Стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн газрын бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.3.Эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж, ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал, ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх, бусад байгууллагын зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.4.Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (газрын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх);

3.2.Бүтцийн хувьд энгийн байх зарчим;

3.2.1.Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);

3.2.2.Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (газрын төрийн захиргааны албан хаагч нь Монгол Улсын Шадар сайд, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн алжааа нөлөөнд астахгүй, төвийг сахисан байх);

3.2.3.Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн дайчлан илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.3.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг

3.4.9. Ургамал, ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар, өюулгүй байдал, хорио цээрийн сорилт шинжилгээний лабораторийн үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд бүх төрлийн тарималт ургамлын үр, үр тарианд тариалалтын болон технологийн чанарын шинжилгээ болон ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээрийн шинжилгээг гадаад, дотоод хорио цээртэй хортон шавж, хачиг, хог ургамал, ургамлын өвчин илрүүлэн тодорхойлох зэрэг үзүүлэлтээр гүйцэтгэх, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай дүн шинжилгээ, мэдээ, мэдээллээр хангах, үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

бүрэн ээлжит, хэсэгчилсэн магадлал, баталгаажилтыг хийнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, гол түнш зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байна.

3.4.6. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх биологийн бохирдлыг тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүн, орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээг бактери, вирус, хөгц мөөгөнцөр, паразит, биотуршилт, нянгийн эсрэг идэвх, хувиргасан амьд организмын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлох зэрэг үзүүлэлтээр гүйцэтгэж, биологийн бохирдлоос гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай дүн шинжилгээ, мэдээ, мэдээллээр хангах, үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.4.7. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх химийн бохирдлыг тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, орчны химийн чанар, аюулгүй байдлын шинжилгээг хүнд металл, токсин, пестицид, эмийн үлдэгдэл, хүнсний нэмэлт, микотоксин, хүнд метал, харшил үүсгэгчид зэрэг бусад химийн үзүүлэлтээр тодорхойлох, үлдэгдэл бодис, химийн бохирдлоос гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай дүн шинжилгээ, мэдээ, мэдээллээр хангах, үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.

3.4.8. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх физикийн бохирдлыг тодорхойлох сорилт шинжилгээний лабораторийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, гадаад орчин, барилгын материал, түүний түүхий эдэд байгалийн болон зохиомол цацраг идэвхт изотоп тодорхойлох, цацраг идэвхт ашигт малтмал, түүний хайгуул, олборлолт, ашиглалтын үед болон цөмийн онош зүй, туяа эмчилгээ, бусад цацрагийн үүсгүүртэй харьцдаг ажиллагсдын цацрагийн шарлагын тунг үнэлэх, ажлын байран дахь цацрагийн тунг, тунгийн чадлыг хэмжих, рентген оношилгооны аппаратны чанарын хяналтын хэмжилт хийх, цацрагийн үүсгүүр тодорхойлох, цацрагийн бохирдлоос гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай дүн шинжилгээ, мэдээ, мэдээллээр хангах, үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь ХАБҮЛЛ-ийн Захирал, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, ажилтнууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Стандарт, хэмжил зүйн газар, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байна.